



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 582

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 188,967,906.00 (нэг зуун наян найман сая есөн зуун жаран долоон мянга есөн зуун зургаа) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Мэдээлэл холбооны сүлжээ" хязгаарлагдмал хариуцлагатай компани (Орхон аймгийн газар)-ийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2."Мэдээлэл холбооны сүлжээ" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбат, Орхон аймгийн Засаг дарга М.Түмэнжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132002335
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн
28 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
/ОРХОН АЙМГИЙН ГАЗАР/-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон огноо	Бүртгэх дүн (төгрөг)	Гүйцэтгэсэн байгууллага
1	17 худаг 1620м сувагчлал	Орхон аймгийн Баянбулаг, Их залуу, Шанд, Даваат баг	2024	188,967,906.00	Мөнх дархан хангай ХХК
	Нийт дүн			188,967,906.00 (нэг зуун наян найман сая есөн зуун жаран долоон мянга есөн зуун зургаа)	